

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 06 ДУГААР ХУРАЛ**

2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 15 цаг 25 минутад эхэлж, мөн өдрийн 16 цаг 10 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 00 цаг 45 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн 2020 оны “Хошой аварга малчин”, “Аварга малчин”, “Аварга тариаланч”, “Аварга саальчин” нэмж шалгаруулах тухай	Аймгийн аварга малчинаар Алтай сумын Барлаг багийн Чагнаагийн Түмэндэмбэрэл, Дуут сумын Хөхбэлчир багийн Намадын Дүүдээ, аймгийн хошой аварга малчинаар Зэрэг сумын Бургасан багийн Батаагийн Ганхүү, аймгийн аварга саальчинаар Буянт сумын Цагаанбулан багийн Рэнцэнгийн Цэцэгдарь, Төмөрбаатарын Оролмаа, аймгийн аварга тариаланчаар Ховд сумын Дунд ус багийн Молдагажийн Серикберген, Дарви сумын Булган багийн Ёндонгийн Дагвадорж нарын ирүүлсэн материалыг дахин хянаж үзээд тус тус нэмж шалгаруулахаар дэмжин нэрсийг захирамжид нэмж оруулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүхэд үүрэг болгов.
2	Ховд аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын “Прогресс” дунд сургуулийг Монгол улсын гавъяат багш, ахмад сурган хүмүүжүүлэгч, зөвлөх багш Гунгаажанцангийн Дашдондогийн нэрэмжит болгох тухай	Ховд аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын “Прогресс” дунд сургуулийг Монгол улсын гавъяат багш, ахмад сурган хүмүүжүүлэгч, зөвлөх багш Гунгаажанцангийн Дашдондогийн нэрэмжит болгох тухай хэлэлцүүлэн дэмжиж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Даваадоржид үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР